

## 1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд ....тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

## 2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12			
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10			
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6			
4	Аудит, хяналтын тогтолцоо	6			
5	Эрсдэлийн удирдлага	8			
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6			
7	Оролцогч талуудын эрх ашиг	8			
8	Компанийн соёл	6			
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10			
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>			

## 3. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- 3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 3.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

#### 4. Үнэлгээний асуулга

#### “ТАЛХ ЧИХЭР” ХК

/нэр/

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэг жилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Тийм	ТУЗ-н үйл ажиллагааны журам болон компанийн дүрэмд нарийвчлан зохицуулсан.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Тийм	ЗХНЖ-004 Сонгон шалгаруулалтын журамтай бөгөөд 360°-р ур чадварыг үнэлж, ТЧЖ-037 Байгууллагын мэдлэгийн журмад залгамж халааны бодлогыг тусгасан.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	Тийм	Хувь эзэмшигчдийн хуралд ТУЗ-н үйл ажиллагааг тайлагнаж, компанийн болон хөрөнгийн биржийн вейб сайтад байршуулдаг.	2	100%
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Тийм	ТУЗ-н Аудитын, Цалин урамшуулалын, Нэр дэвшүүлэх гэсэн 3-н хороотой. Тус бүрт бодлогын баримт бичигт тусгаж өгсөн шалгууртай бөгөөд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор 60:40%-н харьцаатай ажиллаж байна.	2	100%
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох,</i>	Тийм	Компанийн засаглалын сургалтанд хамруулан сертификатуулж, ТУЗ-н үйл ажиллагааны журам, Дэд хороодын бодлогын баримт бичиг, үүрэг хариуцлага,	2	100%

	<i>тэдгээрийгшинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>		шалгуурыг танилцуулж, тогтмол сургалтанд хамруулдаг.		
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Тийм	ТУЗ-ийн дарга нь эрх бүхий албан тушаалтны хувьд компанийн тухай хууль, дүрэм жухамд зааснаар хариуцлага хүлээнэ. ТУЗ-н үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	2	100%
ДҮН					
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Тийм	Одоогоор хараат бус гишүүдийн харьцаа 3/1 байна. Цаашид хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх бодлого барьж байна.	2	100%ы
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Тийм	Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Л.Дамдинсүрэн ажилладаг/бодлогын баримт бичигтэй/. Аудитын хорооны дарга нь ТУЗ-н дарга бус, хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан.	2	100%
9	<i>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урмшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Тийм	Цалин урамшуулалын даргаар ТУЗ-н хараат бус гишүүн Х.Гиймаа ажилладаг /бодлогын баримт бичигтэй/. ТУЗ-н дарга бус, хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан.	2	100%
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Тийм	Нэр дэвшүүлэх хорооны даргаар хараат бус гишүүн Д.Баярсайхан ажилладаг /бодлогын баримт бичигтэй/. ТУЗ-н дарга бус, хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан.	2	100%
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын</i>	Тийм	Түр хороо байхгүй. ТУЗ-н дэргэдэх байнгын үйл ажиллагаатай Дэд 3-н хороотой. Мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий 9-гишүүн бүрэлдэхүүнтэй.	2	100%

	турилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.				
ДҮН					
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b> ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Тийм	Компанийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланг хагас жилээр, бүтэн жилийн тайланг тайлагнаж өөрийн компанийн вейб сайтад, хөрөнгийн биржийн сайтад байршуулдаг. Мөн Бодлого, Зорилт, Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлс нээлттэй ил тод вейб сайтад байршуулдаг.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Тийм	Цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээллэдэг.	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Тийм	Санхүүгийн эрсдлийг ТЧЖ-042 Эрсдлийг удирдах журмаар зохицуулж, жил бүр эрсдлийг матрицын аргаар үнэлж, эрсдлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж ажилладаг.	2	100%
ДҮН					
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b> ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүрэгээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Тийм	Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй хөндлөнгийн аудитын байгууллагатай гэрээтэй ажилладаг. Уг үйл ажиллагаанд Аудитын хороо хяналт тавьж ажилладаг.	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Тийм	Хөндлөнгийн аудитор С.Дүгэртэй гэрээгээр ажилладаг бөгөөд хувь эзэмшигчдийн хуралд дүгнэлтээ танилцуулдаг.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Тийм	• Компанийн хэмжээнд менежментийн тогтолцооны дотоод аудиторын гэрчилгээтэй 25-хүний бүрэлдэхүүнтэй баг ажилладаг. Дотоод аудитыг жилдээ 2 удаа зохион байгуулах хөтөлбөр , төлөвлөгөөтэй.	2	100%

			<ul style="list-style-type: none"> <li>Хүнсний Аюулгүй байдлын ISO 22000:2018-стандартын хэрэгжилтэнд ОУ-ын TUV AUSTRIA- гадны хөндлөнгийн аудитын байгууллагаар жилд тутам магадлан аудит ордог.</li> </ul>		
ДҮН					
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Тийм	Компанийн хэмжээнд ТЧЖ-042 Эрсдлийг Удирдах журмаар зохицуулж, Эрсдлийн баг 8- гишүүдтэй. Эрсдлээ үнэлж, эрсдлийн менежментийн төлөвлөгөөг жил бүр гаргаж хэрэгжүүлдэг. Хараат бус байх зарчмыг сургалтаар олгодог.	2	100%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Тийм	ТУЗ-н дэргэд эрсдлийг удирдах хороод байхгүй боловч Компанийн хэмжээнд Эрсдлийг удирдах журам, баг бүрэлдэхүүн, бүтэцтэй. Удирдлагын дүн шинжилгээний хуралыг төлөвлөгөөний дагуу явуулж, эрсдлийг залруулах арга хэмжээг хугацаатай үүрэг даалгавар өгч, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг.	2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Тийм	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн хэмжээнд БОАЖЯ-наас Байгаль орчны нарийвчласан үнэлгээг хийж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг.</li> <li>ХАБЭА-н нөхцлийн нарийвчласан үнэлгээ, Гамшгийн эрсдлийн үнэлгээг хийлгүүлж, төлөвлөгөө гарган дүрэм, журмаар зохицуулж ажилладаг.</li> </ul>	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Тийм	ТЧЖ-010 Дотоод хяналтын журмын дагуу Ерөнхий менежерээр ахлуулсан 14-хүний бүрэлдэхүүнтэй баг комплайнсын хяналтыг үнэлж, залруулах арга хэмжээг мэдэгдэх хуудсаар өгч, үр дүнгийн тайланг Гүйцэтгэх захиралд танилцуулдаг бөгөөд хараат бус байж чаддаг.	2	100%

35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Тийм	Хувьцаа эзэмшигчдээс авах саналын холбогдох материалыг урьдчилан бэлдэж, танилцуулан цахимаар болон биеэр өгөх өрөө тасалгаа шаардлагатай бусад зүйлээр хангаж өгдөг.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Тийм	Тусгайлсан журам одоогоор байхгүй боловч ТУЗ-ийн гишүүдэд өгөх сургалтандаа уг сэдвийг оруулж өгч зохих мэдлэгийг өгдөг. Цаашид уг асуудлыг зохицуулах журмыг боловсруулахыг төлөвлөгөөндөө тусгав	1,5	75%
ДҮН					
НЭГДСЭН ДҮН					